



Батлан хамгаалах яам



Батлан хамгаалахын эрдэм
шинжилгээний хүрээлэн

ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН - 2019

Захиалагч:

- Батлан хамгаалах яам

Гүйцэтгэгч:

- Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн



13300 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Улаанхуаран, 16-р хороо ҮБХИС

Утас: 453942, Факс: (976) 70150173,

E-Mail: mids@mndu.gov.mn, www.mids.gov.mn

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Хэрэглэгчдийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг үндэслэн БХЭШХ-ийн Батлан хамгаалах дүн шинжилгээний төв 2019 оны нэгдүгээр улиралд Батлан хамгаалах салбарын хэрэглэгчдийн үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэв.

Хэрэглэгчдийн үнэлгээг гаргахдаа уг удирдамжийн хүрээнд 1224 гэж тогтоосон бөгөөд уг түүвэр нь Үндэсний хэмжээний нийт насанд хүрсэн хүн амд эзлэх эх олонлогийн 0.1 хувийг хамарсан бөгөөд итгэх түвшин, алдааны хязгаар 2.5 хувь байгаа нь /хүлээн зөвшөөрөх алдааны хязгаарыг 3-4 хувь гэж тогтоосон/ статистикийн хувьд хүчинтэй түүврийн хэмжээ, 95 хувийн итгэх түвшний шаардлагыг хангаж байгаа болно.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны зорилго нь батлан хамгаалах салбар Батлан хамгаалах яам болон бусад байгууллага түүний бүтээгдэхүүн, үйлчилгээнд өгч буй хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тогтооход оршино.

Судалгааны зорилт:

Судалгааны зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын талаарх хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох;
- Зэвсэгт хүчний талаарх олон нийтийн санал бодлыг тодорхойлох;
- Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, түүний харьяа байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны үнэлгээг хийх;
- Энхийг дэмжих болон олон улсын бусад ажиллагаанд Монгол улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн оролцож байгаа талаарх олон нийтийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох;
- Оюутан-цэрэг хөтөлбөрийн хэрэгжилт, цэрэг татлагын үйл ажиллагааны үнэлгээг тодорхойлох;
- Батлан хамгаалахын багц хуулийн талаарх мэдлэг мэдээллийг тодорхойлох;

Судалгааны түүвэрлэлт, судалгааны хамарсан хүрээ:

Дээрх зорилго зорилтуудыг хангахын тулд Монгол Улсын нийслэлийн 6 дүүргийг хамруулсан 1224 хүн хамруулан сэтгэл ханамжийн судалгаа авсан.

Судалгааны багийн зүгээс судалгаанд хамрагдах түүврийн хэмжээг тодорхойлохдоо санамсаргүй түүврийн аргыг сонгосон бөгөөд дээрх судалгааны түүвэр нь судалгааны төлөөлөх чадварыг бүрэн хангана гэж үзэж байна.

Судалгааг 2019 оны 1 дүгээр сараас 2 дугаар сарын хооронд социологийн судалгааны тоон арга болох анкетын асуулгын аргаар явуулж мэдээлэл цуглуулсан.

Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг энэ жилийн хувьд зөвхөн Улаанбаатар хот, түүний 6 дүүргийн хэмжээнд явуулж түүврийн хэмжээ 1224 болж багассан нь судалгааны санхүүжилт, томилолтоор ажиллах, мэдээлэл цуглуулах зардал олгогдоогүйтэй холбоотой байв.

Үзүүлэлт	Утга	Тайлбар
Түүврийн нэгж	1 хүн	1 хүнээс 1 санал асуулга
Түүврийн хэмжээ	1224	Санамсаргүй түүврийн арга /16-аас дээш насны/
Түүврийн төлөөлөх чадвар		Хангагдсан

Мэдээлэл цуглуулалт:

Мэдээллийг асуулгын буюу анкетын судалгааны аргаар цуглуулсан. Судалгааны анкетыг Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Батлан хамгаалах дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтнууд бэлтгэсэн бөгөөд мэдээлэл боловсруулалтыг SPSS 26.0 программ ашиглан үр дүнг нэгтгэв.

Мэдээллийн хяналт:

Төвийн эрдэм шинжилгээний ажилтнууд мэдээллийн үнэн зөв, тодорхой байх зарчмыг хангахын тулд давхар шивэлтийн арга, мэдээлэл боловсруулалтын алдаа бодит байдлыг шалгахын тулд нийт анкетын 15 хувийг гар аргаар давхар тоололт хийж ажилласан байна.

Мэдээлэл боловсруулалт:

Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлохдоо хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн индекс тооцох аргачлал ашиглан дараах томъёоны дагуу тооцож гаргасан.

$$\sum_{k=1}^N [S_k]$$

Үүнд:

CSI – Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн индекс

S – Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин

W – Чухал байдлын үнэлгээ

Үндсэн ойлголтын тайлбар:

Сэтгэл ханамжийн индекс /CSI/ - хэрэглэгчдийн тухайн үзүүлэлтийг илэрхийлэх дэд үзүүлэлтүүд дэх сэтгэл ханамжийн түвшин болон тухайн үзүүлэлтийн хэр чухалчлагдсан байдлыг харьцуулсны үндсэн дээр нийт сэтгэл ханамжийг тоогоор илэрхийлсэн үзүүлэлт.

Сэтгэл ханамжийн түвшин /S/ - Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг илэрхийлэх боломжтой гэж үзсэн үзүүлэлт дээр хэрэглэгчдийн тухайн үеийн сэтгэл ханамжийг тоогоор илэрхийлэх бөгөөд энэ нь хэрэглэгчдийн санал бодлыг тодорхойлох гол үзүүлэлт.

Чухал байдлын үнэлгээ /W/ - Энэ үзүүлэлтээс хэрэглэгчдийн тухайн үзүүлэлтийг хэр чухалчилж байгааг харах боломжтой бөгөөд нөгөө талаар тухайн үзүүлэлтийн сэтгэл ханамжийн индекс тооцоход ямар нөлөөтэйг тоон утгаар харуулсан үзүүлэлт.

Асуулгын бүтэц

Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг БХЭШХ-ийн БХДШТ 7 дахь жилдээ хийж гүйцэтгэж байгаа бөгөөд өмнөх жилүүдэд авч байсан анкетын асуулгаа боловсронгуй болгож, цаг үеийн шаардлагатай асуудлуудыг тусган явуулсан. Судалгааны анкет дараах бүтэцтэй болно.

- Судалгаанд оролцогчийн хувийн мэдээлэл
- Батлан хамгаалах салбарын тухай ойлголт
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх сэтгэл ханамж
- Үнэлгээ

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Батлан хамгаалах салбар нь бодлого, үйл ажиллагаа, менежментийн хувьд тухайн улс орны эдийн засгийн хямрал, улс төр, цаг үеийн нөхцөл байдал, ямар нэгэн гадны хүчин зүйлээс шууд хамаарахгүйгээр бие бүрэлдэхүүний бэлэн байдал, хөрөнгө санхүү, нөөц бололцоо, мэргэжлийн чадавхид суурилсан оновчтой төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт хангагдсан нөхцөлд улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах зорилго бүрэн утгаараа хэрэгждэг.

Судалгааны гол зорилго нь: БХЯ-ны талаар ойлголт, болон бүтээгдэхүүн, үйлчилгээнд өгч буй хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг өмнөх онуудынхтай харьцуулан дүгнэхэд оршиж байгаа юм.

Судалгааны үр дүнгүүд өмнөх онуудтай харьцуулагдан гарч байгаа учир судалгаанд тусч өөрчлөгдсөн асуудлууд нь бодит өсөлт, бууралт гэж ойлгож болно.

2018 онд батлагдсан Батлан хамгаалах салбартай холбоотой хуулийн талаарх иргэдийн мэдлэгийг үнэлэхэд судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 70 орчим хувь нь Дайчилгааны тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Төрийн албаны хууль /шинэчилсэн найруулга/-ийн талаар тодорхой ойлголттой байгаа боловч дунджаар 3 хүний нэг нь эдгээр хуулийн талаар тодорхой ойлголтгүй байгаад анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн Оюутан цэрэг хөтөлбөрийн нийгмийн өгөөж, хэрэгжилтийн үр дүнг нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 34 хувь нь Сайн, 17.8 хувь нь Маш сайн гэж судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 51,8 хувь үнэлсэн нь Оюутан-цэрэг хөтөлбөр иргэн-цэргийн харилцааг төлөвшүүлэх, нийгмийн хүлээлтийг хангаж чадсан Батлан хамгаалах салбарын хувьд ард иргэд рүү чиглэсэн үр дүнтэй ажил болсон гэж дүгнэж болохоор байна.

Энхийг дэмжих болон бусад олон улсын ажиллагаа нь Монгол Улсын болон Зэвсэгт хүчний нэр хүнд, Монгол цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг олон улсад таниулж байгаад ард иргэд болон олон нийт сэтгэл хангалуун байгаа нь судалгаанд оролцогчдын үнэмлэхүй дийлэнх буюу 35,7 хувь Сайн, 19.4 хувь нь Маш сайн /бүлэглэвэл 55,1 хувь/ гэж үнэлсэн нь Монгол Улсын энхийг сахиулах үйл ажиллагааны оролцоог ард иргэд өндрөөр үнэлж байгааг харуулж байна гэж үзэх гэж үнэлсэн үр дүнгээр нотлогдож байна.

БХЯ-ны гадаад харилцаа сүүлийн жилүүдэд ихээхэн өргөжиж зөвхөн энхийг дэмжих ажиллагаагаар хязгаарлагдахгүй өөр олон салбарт гадаадын улс орнуудтай хамтран ажиллаж байгаагийн үр дүнд олон нийт эерэг хандлагатай байгаа нь харагдсан. Үүнд: Авто зам, барилга, дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлууд, тээвэр, оюутан, багш солилцох хөтөлбөр, Зэвсэгт техник болон тоног төхөөрөмжийн сайжруулалт зэрэг олон ажлыг дурдаж болох юм.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Цэргийн штабын үйл ажиллагаа, цэрэг татлагын үйл ажиллагаа, зохион байгуулалттай харьцуулан дүгнэвэл судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 45,9 /Маш сайн, Сайн үнэлгээг бүлэглэв/ хувь нь цэрэг татлагын үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайн, Цэргийн штабын үйл ажиллагааг 34,7 хувь нь Сайн гэж үнэлсэн бөгөөд хувьсагчийн хамаарлын түвшин ойролцоо байгаа нь Цэргийн штабын үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж байна гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байна.


Дээрх судалгааны үр дүнг тоймлон дүгнэвэл Зэвсэгт хүчний нэр хүнд олон нийт болон иргэдийн дунд нэлээд өндөр байна. Үүнийг тоон дүнд шилжүүлэн дүгнэвэл нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 37 хувь нь Зэвсэгт хүчний хүчин чадал, үүрэг гүйцэтгэх чадварт итгэж байгаа гэсэн үзүүлэлт гарсан байна. Энэ нь Зэвсэгт хүчний нийгмийн дунд эзлэх байр суурь эерэг хандлагатай байгааг харуулж байна.

ТҮҮВРИЙН БҮТЭЦ


Судалгаанд оролцогчдийн хүн ам зүйн мэдээлэл:

Судалгаанд 16 – аас дээш насны 1224 хүн оролцов.

Судалгаанд оролцогчдын насны бүтэц:




Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа:




Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин:

Оролцогчдын боловсролын түвшинг доорх хүснэгтээр харууллаа. Үр дүнгээс харахад 91.2 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой байгаа нь судалгааны үр дүнд эерэгээр нөлөөлж байна.

Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин:




Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал:




СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын өрхийн орлогын түвшин:



Судалгаанд ороцогчдоос өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдал тэдний амьдрал ахуйд хэрхэн нөлөөлж буйг тодруулах зорилгоор асуусан **Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн амжиргаа хэрхэн өөрчлөгдсөн бэ?** гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 51.5 хувь нь онцын өөрчлөлт ороогүй хэвэндээ байгаа, 28 хувь нь бага зэрэг дээшилсэн, 5,6 хувь нь мэдэгдэхүйц дээшилсэн гэж хариулсан бол харин сөрөг утга болох бага зэрэг доошилсон гэж 12 хувь нь үзсэн нь өмнөх оноос даруй 2 дахин өсөж бүр дордсон гэж 3 хувь болж өссөн дүнтэй тус тус хариулжээ.




САЛБАР, ЧИГ ҮҮРГИЙН ҮНЭЛГЭЭ

2019 онд батлагдсан Батлан хамгаалах салбартай холбоотой багц хуулийн талаарх иргэдийн мэдлэгийг үнэлэхэд дараах үр дүн гарлаа.

№	Асуудал	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй
1.	Дайчилгааны тухай хууль	18.9	53.7	27.5
2.	Орон нутгийн хамгаалалтын тухай хууль	14.5	53.6	32
3.	Төрийн албаны хууль /шинэчилсэн найруулга/	23.5	49.7	26.8

Дээрх судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 71.3 хувь нь Дайчилгааны тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Төрийн албаны хууль /шинэчилсэн найруулга/-ийн талаар тодорхой ойлголттой байгаа боловч дунджаар 3 хүний нэг нь эдгээр хуулийн талаар тодорхой ойлголтгүй байгаад анхаарах шаардлагатай байна.

Судалгааны үндсэн зорилгын нэг болох Монгол Улсын Зэвсэгт хүчний талаарх олон нийтийн мэдлэг, мэдээлэл, үйл ажиллагааны талаарх ойлголтыг тодруулах зорилгоор асуусан Та өөрийгөө Монгол Улсын Зэвсэгт хүчний талаар хангалттай мэдээлэл авч чадаж байна уу? гэсэн асуултад иргэдийн хариулсан байдал:




Дээрх дүнгээс үзэхэд Зэвсэгт хүчний талаарх мэдээллийн хүртээмж 2017, 2018 онтой харьцуулахад Маш сайн үнэлгээ 2.4, Сайн үнэлгээ 6.6 функтээр буурсан бол мэдээллийн хүртээмж Муу үнэлгээ 4.1 хувь, Маш муу үнэлгээ 2.8 хувиар өссөн нь БХЯ болон ЗХЖШ-ын зүгээс иргэдэд бодитой, хүртээмжтэй мэдээлэл хүргэх ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Харин Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагааны талаарх олон нийтийн үнэлэмж 2019 онд эерэг хандлагатай байгаа нь доорх судалгааны дүнгээс харагдаж байна.


Тодруулбал судалгаанд оролцогчдын 32,9 хувь нь /маш сайн, сайн хариултыг бүлэглэв/ Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна.

Гэхдээ 2016, 2017, 2018 оны үнэлгээг харьцуулан үзвэл Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагааны талаарх олон нийтийн эерэг үнэлэмж 8 функтээр багассан байгаа нь харагдаж байна.



Монгол Улсын Зэвсэгт хүчний улс орон, ард иргэдийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа эсэх, иргэдийн Зэвсэгт хүчиндээ итгэх итгэлийг ойлголт, төсөөллийг тандах зорилгоор асуусан **“Монгол Улсын Зэвсэгт хүчний**


чадавхыг ямар хэмжээнд байна гэж Та бодож байна вэ? асуултад судалгаанд оролцогчдын хариулсан байдлыг харьцуулан үзвэл:



2019 онд судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 42.6 хувь нь Зэвсэгт хүчний хүчин чадал, үүрэг гүйцэтгэх чадвар Дунд зэрэг, 27.1 хувь нь Сайн гэж үнэлсэн нь Зэвсэгт хүчний нийгмийн дунд эзлэх байр суурь эерэг хандлагатай байгааг харуулж байна.

Гэсэн хэдий ч өмнөх оны мөн үеэс даруй 8 хувиар буурсан үзүүлэлттэй байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Харин Муу буюу Маш муу гэж судалгаанд оролцогчдын 13 хувь нь үзсэн нь өмнөх жилийн үзүүлэлтээс 4.9 функтээр буурсан байгаа нь сайн үзүүлэлт харагдаж байна.


Зэвсэгт хүчний **офицер, ахлагч, цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлагын талаарх иргэдийн ойлголт, төсөөллийг тодруулахад** судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 41.7 хувь нь Дунд, 32.5 хувь нь Маш сайн, Сайн гэж үнэлсэн байна. Харин Маш муу үнэлгээ нэмэгдэж 4.3 хувь болсон байна.




2019 оны судалгааны дүнг 2018 оны мөн үеийн судалгааны үр дүнтэй харьцуулсан үнэлгээнээс үзэхэд Зэвсэгт хүчний офицер, ахлагч, цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлагын байдлыг Сайн гэж үнэлсэн үнэлгээ өмнөх оныхоос 9 функтээр илүү буурсан нь харагдаж байна.

Нийгэм болон Зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагааны гол үр дүн нь иргэн цэргийн харилцаа хэрхэн төлөвшсөнөөс ихээхэн шалтгаалдаг. Энэ утгаараа судалгааны дараагийн асуулт болох **“Та Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, иргэн-цэргийн харилцаа өнөөдөр ямар түвшинд байна гэж бодож байна вэ?”** гэсэн асуултад 2019 онд судалгаанд оролцогчдын 5 хувь нь Маш сайн, 19,9 хувь нь Сайн, 47,8 хувь нь Дунд, 12,2 хувь нь Муу, үлдсэн хэсэг нь Мэдэхгүй гэсэн хариулт өгсөн нь Монгол Улсад иргэн-цэргийн харилцаа, иргэний хяналтын зохистой загвар төлөвшиж байна гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байна.

Гэсэн хэдий ч өнгөрсөн жилийн мөн үеэс сайн үзүүлэлт дундажаар 5 функтээр буурсан байгааг анхаарч үзэх шаардлагатай.




Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабаас зохион байгуулж буй иргэд, олон нийтийн дунд бодлого үйл ажиллагаагаа сурталчлан таниулах ажлын чанар хүртээмжийг үнэлнэ үү? гэсэн судалгааны дараагийн асуултад хариулсан байдлыг танилцуулбал:



Дээрх судалгааны дүнгийн Сайн болон Муу гэж хариулсан сонголтын зөрүү 13 хувь байгаа нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабаас


иргэдийн дунд явуулж буй Зэвсэгт хүчнийг сурталчлах үйл ажиллагаа тодорхой үр дүнд хүрч байна гэж дүгнэж болохоор байна.

Монгол Улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний харьяа байгууллагуудын явуулж буй үйл ажиллагааг судалгаанд оролцогчдын үнэлсэн байдлыг 2016, 2017, 2018 оны судалгааны үр дүнтэй харьцуулан танилцуулбал дараах дүр зураг харагдаж байна.




Судалгааны дараагийн асуулт болох **Та Монгол Улсын энхийг сахиулах үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлнэ үү?** гэсэн асуултад 2019 онд нийт судалгаанд оролцогчдын үнэмлэхүй дийлэнх буюу 33,8 хувь Сайн, 30,5 хувь нь Маш сайн /бүлэглэвэл 64,3 хувь/ гэж үнэлсэн нь Монгол Улсын энхийг сахиулах үйл ажиллагааны оролцоог ард иргэд өндрөөр үнэлж байгааг харуулж байна гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэ үзүүлэлт даруй 10 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь энхийг дэмжих ажиллагааны цар хүрээ, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл хэрхэн өсөн нэмгдэж буйн илрэл болно.




Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар хэрэгжиж буй Засгийн газрын 2014 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан Оюутан-цэрэг хөтөлбөр нийгмийн сэтгэл зүйд хэрхэн тусгалаа олж буйг үнэлэх зорилгоор асуусан **“Оюутан цэрэг” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх Таны үнэлгээ?** асуултад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулжээ.




Дээрх судалгааны дүнгээс үзэхэд 2019 онд Оюутан цэрэг хөтөлбөрийн нийгмийн өгөөж, хэрэгжилтийн үр дүнг нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 37,7 хувь нь Сайн, 14,3 хувь нь Маш сайн гэж судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 52 хувь үнэлсэн нь Оюутан-цэрэг хөтөлбөр иргэн-цэргийн харилцааг төлөвшүүлэх, нийгмийн хүлээлтийг хангаж чадсан Батлан хамгаалах салбарын хувьд ард иргэд рүү чиглэсэн үр дүнтэй ажил болсон, өдгөөг хүртэл нийгэмд ийм эерэг хандлага хүргэж байна гэж дүгнэж болохоор байна.

Судалгаанд оролцогчдын Нийслэл, орон нутаг цэрэг татлагын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг, Нийслэл, орон нутгийн Цэргийн штабын үйл ажиллагааны үнэлгээтэй харьцуулан графикаар үзүүлбэл:




Судалгааны үр дүнгээс үзэхэд 2019 онд Цэргийн штабын үйл ажиллагааг 37,7 хувь нь Сайн, 14,3 хувь нь Маш сайн гэж үнэлсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй үнэлгээний хувьсагч хамаарлын түвшин ойролцоо байгаа нь Цэргийн штабын үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж байна гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байна.

Харин жил бүр зохион байгуулагдаж буй цэргийн насны залуучуудыг цэрэгт татах үйл ажиллагааны зохион байгуулалт хэрхэн явагдаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хэр байгааг тодруулсан үр дүнг доор өмнөх онтой харьцуулсан графикаар үзүүлэв.




Батлан хамгаалах салбарын ил тод, нээлттэй байдлын түвшинг үйл ажиллагааны болон төсвийн ил тод байдал гэсэн хоёр хувьсагчаар тодорхойлоход Батлан хамгаалах салбарын үйл ажиллагааны нээлттэй байдал төсвийн ил тод байдлын уялдаа холбоо зохих түвшинд байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.



Түүнчлэн судалгаанд оролцогчдын үнэлгээнээс тоймлон үзэхэд Батлан хамгаалах салбарын ил тод, нээлттэй байдлыг эерэг үнэлгээ сөрөг үнэлгээний харьцааг үзвэл ойролцоо судалгааны үр дүн гарсан байна.

Үзүүлэлт	Эерэг		Сөрөг	
	2018	2019	2018	2019
Батлан хамгаалах салбарын үйл	25,3	32	21,4	13,1


ажиллагааны ил тод байдал				
Батлан хамгаалах салбарын төсвийн ил тод байдал	23,9	25	21,5	17,1



Харин өнгөрсөн оны мөн үеийн эерэг сөрөг хандлагын үзүүлэлтийг 2019 оны судалгааны дүнтэй харьцуулан үзвэл тус бүр эерэг үзүүлэлт харьцангуй өсөлттэй, сөрөг үзүүлэлт бууралттай гарсан нь сайн үзүүлэлт болж байна.

Энхүү үзүүлэлт нь батлан хамгаалах салбарын нээлттэй ил тод байдал, төсвийн зарцуулалт тайлагнал зэрэг үйл ажиллагаа нь иргэдэд хүрч, тодорхой хэмжээний эерэг хандлагыг бүрдүүлэх ажиллагаа эрчимжсэний илрэл гэж үзэж болно.

Зэвсэгт хүчнийг **улс орны стратегийн бүтээн байгуулалтад оролцуулснаар** Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, үндэсний хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, ажиллах хүчний төлөвшилд дэмжлэг үзүүлэх, залуучуудын эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх зорилтуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой хэдий ч энэхүү үйл ажиллагааг иргэд хэрхэн үнэлж байгааг тандаж асуусан асуултанд хариулсан байдлыг графикаар үзүүлэв.



Судалгааны үр дүнгээс үзэхэд цэргийн хүчин улс орны бүтээн байгуулалтанд оролцож буй нь Сайн хэрэг гэж 29,6 хувь нь, Маш сайн хэрэг гэж 11,6 хувь нь нийлбэрлэн бүлэглэж үзвэл эерэг хандлагаар үнэлж буй үнэлгээ 41,2 хувь болж байна. Үүн дээр дундаж үнэлгээ өгсөн иргэд 32,8 хувийг эзэлж байна. Харин Муу болон Маш муу үнэлгээ өгсөн иргэд цөөнгүй буюу 10,9 хувь байгааг анхаарч үзэх шаардлагатай. Мөн энэхүү оролцоо нь зөв буруу, сайн муу эсэх талаар мэдэхгүй гэж үзсэн иргэд эзлэх хувь ч багагүй буюу 15,2 хувь байна.

СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН:

БХЭШХ-ИЙН БХДШТ-ИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Т.СОРОНЗОНБОЛД

БХЭШХ-ИЙН БХДШТ-ИЙН ЭША,
ДЭД ХУРАНДАА

Б.НЭРГҮЙ

ГАРЫН ҮСГИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:

БХЭШХ-ИЙН ДЭД ЗАХИРАЛ, ЭНБД
ХУРАНДАА

Ч.БАТТУЛГА